



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь “Монгол Даатгал” ХК-д учирч болзошгүй эрсдэлийг эрт илрүүлэн, тохиromжтой арга аргачлал ашиглан үнэлэн, зохистой удирдснаар байгууллагын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, зорилго зорилтууддаа хүрэхдээ туслахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Даатгалын тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид “СЗХ” гэх)-оос гаргасан заавар, журмын хүрээнд мөрдөгдөнө.
- 1.3 Энэхүү журам нь байгууллагын дотоод болон гадаад бүх шатны үйл ажиллагаанд хэрэгжих ба байгууллагын засаглалын хүрээнд бүх шатны ажилтан, гэрээт ажилтан болон сайн дурын ажилтнуудад хамаарна.
- 1.4 Дор дурдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.4.1 “Эрсдэл” - Тавьсан зорилгодоо хүрч чадахгүй байх үйл ажиллагааны сөрөг хазайлтыг;
 - 1.4.2 “Эрсдэлийн аппетит” – Компанийн тухайн эрсдэлд хандах хандлагыг;
 - 1.4.3 “Эрсдэл даах чадвар” - Учирч болох хохирлыг компанийн бизнесийн хэвийн үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр хүлээх чадвар;
 - 1.4.4 “Эрсдэлийн удирдлага” - Эрсдэлээс зайлсхийх, эрсдэлийг багасгах, шилжүүлэх, ерөнхийд нь удирдах зорилго бүхий удирдлагын бүхий л арга хэмжээг.
 - 1.4.5 “Эрсдэлийн Удирдлагын Систем” - Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, тооцоолох замаар удирдах боломжтой болгох зорилго бүхий системийг;
 - 1.4.6 “Эрсдэлийн мэдээллийн сан”- компанийн бизнесийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бүхий л мэдээллийг;
 - 1.4.7 “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан” – Компанийн ирээдүйд учирч болзошгүй эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэн гаргасан тайланг;
 - 1.4.8 “Var (95)” – Түүхэн мэдээлэл дээр үндэслэн гаргасан хамгийн эрсдэлтэй утга;

2. ЭРСДЭЛИЙН ЗАСАГЛАЛ

- 2.1 Байгууллагын эрсдэлийн засаглалын бүтэц тодорхойлогдсон байна. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх), удирдлагын баг болон бүх шатны ажиллагсдын эрсдэлийн удирдлагын хүрээнд хийгдэх ажлууд болон үүрэг, хариуцлага нь тодорхойлогдсон байна. Үүнд:

- 2.1.1 ТУЗ нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам, стратегийг батлах, эрсдэлийн аппетит болон эрсдэл даах чадварыг тодорхойлох үүрэгтэй.
- 2.1.2 Удирдлагын баг нь эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлох болон эрсдэлийн удирдлагын стратегийг боловсруулах үүрэгтэй.
- 2.1.3 Гүйцэтгэх захирал нь байгууллагын хэмжээнд эрсдэлийн соёлыг сайжруулах болон жил бүрийн эцэст хийгдэх “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан”-тай танилцаж, батлах үүрэгтэй.

- 2.1.4 Дотоод аудитор нь эрсдэлийн удирдлагын бодлого, журмын хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй.
- 2.1.5 Эрсдэлийн удирдлагын алба нь жил бүр “Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан” гаргаж СЗХ -нд тайлagnaх, улирал бүр “Эрсдэлийн удирдлагын тайлан”-г гаргаж ТУЗ болон удирдлагын багт тайлagnaх болон эрсдэлийн мэдээллийн санг бүрдүүлж, чанарт нь хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 2.1.6 Газрын захирлууд болон менежерүүд нь газар нэгж, хэлтсийн ажилтнуудаа эрсдэлийн удирдлагын бодлого, журмын дагуу ажиллах боломжоор хангах үүрэгтэй.
- 2.1.7 Ажиллагсад нь эрсдэлийн удирдлагын бодлого, журмыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах үүрэгтэй.

3. ЭРСДЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ХАРИУЦАГЧ

- 3.1 Байгууллагад учирч болзошгүй эрсдэлүүдийг тухайн эрсдэлийн онцлог, шинж чанараас хамааруулан даатгалын эрсдэл, санхүүгийн эрсдэл, стратегийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл болон комплайнсын эрсдэл гэсэн үндсэн таван булэгт ангилна.
- 3.2 Даатгалын үйл ажиллагаатай холбоотой буюу даатгалын гэрээний андеррайтинг болон нөхөн төлбөр олгохтой холбоотой эрсдэлийг даатгалын эрсдэл ангилалд оруулна. Үүнд дараах эрсдлүүд хамаарна:
 - 3.2.1 **Хураамжийн эрсдэл** гэж бодит хохирлын харьцаа болон зардлын харьцаа нь таамагласан хохирлын харьцаа болон зардлын харьцаанаас өндөр гарах эрсдэлийг хэлнэ. Хариуцагч нь даатгалын газар болон бизнес хөгжлийн газар байна.
 - 3.2.2 **Нөөц сангийн эрсдэл** гэж учирсан боловч мэдэгдээгүй болон мэдсэн боловч төлөгдөөгүй хохиролд зориулан байгуулсан нөөцийн сан нь бодит хохирлыг төлөхөд хүрэлцэхгүй байх эрсдэлийг хэлнэ. Хариуцагч нь актуарч байна.
- 3.3 Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой гарч болох эрсдлүүдийг санхүүгийн эрсдэл ангилалд оруулна. Үүнд дараах эрсдлүүд хамаарна:
 - 3.3.1 **Зээлийн эрсдэл** гэж харилцагч банк болон давхар даатгалын компани дампуурах эсвэл үйл ажиллагаа нь доголдох, даатгалын болон бусад авлагатай этгээдүүд авлагаа төлөхгүй байх, даатгагчийн хөрөнгө оруулсан үнэт цаас гаргагч дампуурах эсвэл үйл ажиллагаа нь доголдсны улмаас учрах санхүүгийн алдагдлыг хэлнэ.
 - 3.3.2 **Зах зээлийн эрсдэл** гэж хадгаламж байршуулсан банкны хүү буурах, валютын ханшны өөрчлөлт, хөрөнгө оруулсан үнэт цаасны үнэлгээ унах болон үндсэн хөрөнгийн элэгдэл зэрэг шалтгаануудын улмаас учрах санхүүгийн алдагдлыг хэлнэ.
 - 3.3.3 Санхүүгийн эрсдэлийн хариуцагч нь санхүүгийн газар байна.
- 3.4 Байгууллагын баримталж буй бодлого, стратегитэй холбогдон гарч болох эрсдлүүдийг стратегийн эрсдэл ангилалд оруулна. Үүнд дараах эрсдлүүд хамаарна:
 - 3.4.1 **Засаглалын эрсдэл** гэж төлөөлөн удирдах зөвлөл болон удирдлагын багийн үүрэг, хариуцлага тодорхойгүй байдлын улмаас засаглалын хямрал үүсч болзошгүй эрсдэлийг хэлнэ.
 - 3.4.2 **Андеррайтингийн бодлогын эрсдэл** гэж андеррайтингийн бодлого байхгүй эсвэл сул байгаагийн улмаас компанийн хураамжийн орлого, ашигт ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг хэлнэ.

- 3.4.3 **Давхар даатгалын бодлогын эрсдэл** гэж давхар даатгалын хамгаалалт хэрэгцээ шаардлагаасаа илүү эсвэл дутуу гарсны улмаас учирч болзошгүй санхүүгийн алдагдлыг хэлнэ.
- 3.4.4 **Хөрөнгө оруулалтын бодлогын эрсдэл** гэж хөрөнгө оруулалтын бодлого байхгүй эсвэл хөрөнгө оруулалтын алдаатай бодлогын улмаас үүсч болзошгүй санхүүгийн алдагдлыг хэлнэ.
- 3.4.5 Стратегийн эрсдэлийн хариуцагч нь удирдлагын баг байна.
- 3.5 Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбогдон гарч болох эрсдлүүдийг үйл ажиллагааны эрсдэл ангилалд оруулна. Үүнд дараах эрсдлүүд хамаарна:
- 3.5.1 **Мэдээлэл алдагдах эрсдэл** гэж байгууллагын бүх төрлийн мэдээлэл алдагдсны улмаас учирч болзошгүй эрсдэлийг хэлнэ. Хариуцагч нь мэдээлэл технологийн хэлтэс байна.
 - 3.5.2 **Хүний нөөцийн эрсдэл** гэж ажилтнууд ажлаас гарснаар байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах болон борлуулалтын ажиллагсад ажлаас гарснаар харилцагчаа алдах эрсдлийг хэлнэ. Хариуцагч нь захиргаа, хүний нөөцийн хэлтэс байна.
 - 3.5.3 **Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэл** гэж хууль эрх зүйн хүрээнд болон зохицуулагч байгууллагаас гарсан шийдвэрүүдийн улмаас учирч болзошгүй эрсдлүүдийг хэлнэ. Хариуцагч нь эрх зүй, тусгай активын алба байна.
 - 3.5.4 **Залилангийн эрсдэл** гэж нөхөн төлбөр авч буй харилцагч санаатай болон санамсаргүй байдлаар бодит хохирлоос давсан нөхөн төлбөр нэхэмжлэх эсвэл, нөхөн төлбөр олгохгүй тохиолдолд нөхөн төлбөр нэхэмжлэн авсны улмаас үүсэх санхүүгийн алдагдлыг хэлнэ. Хариуцагч нь нөхөн төлбөрийн хэлтэс байна.
 - 3.5.5 **Авлагын эрсдэл** гэж буруутай этгээдээс авч буй авлага төлөгдөхгүй байх, төлөгдсөн тохиолдолд авлагын төлөлтөнд тавих хяналт сул байгаагийн улмаас учирч болзошгүй санхүүгийн алдагдлын хэлнэ. Хариуцагч нь эрх зүй, тусгай активын алба байна.
- 3.6 Хууль тогтоомж, дүрэм журам, ёс зүйн хэм хэмжээ болон байгууллагын дотоод бодлого зэрэг зөрчигдсөнөөс үүсэх эрсдэлийг комплайнсын эрсдэл ангилалд оруулна. Үүнд дараах эрсдлүүд хамаарна:
- 3.6.1 **Ажиллагсадтай холбоотой эрсдэл** гэж ажиллагсад ёс зүй, хууль, дүрэм журмыг зөрчснөөс гарч болох эрсдэлийг хэлнэ.
 - 3.6.2 **Мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэх эрсдэл** гэж санаатай болон санамсаргүй байдлаар мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлснээс гарч болох эрсдэлийг хэлнэ.
 - 3.6.3 Комплайнсийн эрсдэлийн хариуцагч нь комплайнс хариуцсан ажилтан байна.

4. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ, ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАР

- 4.1 Хураамжийн эрсдэлийг даатгалын хэлбэр тус бүр дээр тооцох ба нийт хураамжийн эрсдэл нь даатгалын хэлбэр тус бүр дээрх хураамжийн эрсдэлийн нийлбэртэй тэнцүү байна.
- 5.4.1 Хураамжийн эрсдэл нь тухайн даатгалын хэлбэр дээрх хураамжийн эрсдэлийн коефициентийг тухайн хэлбэрийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц болон учирч болзошгүй хохирлын нөөц сангудын нийлбэрээс давхар даатгалын хойшлогдсон хураамжийг хассанаар үржүүлсэнтэй тэнцүү байна.
 - 5.4.2 Хураамжийн эрсдэлийн коефициент нь тухайн хугацаанд хүлээгдэж буй хохирлын харьцааны VaR (95) утга болон дундаж утгын зөрүүтэй тэнцүү байна.

- 4.2 Нөөцийн сангийн эрсдэлийг даатгалын хэлбэр тус бүр дээр тооцох ба нийт нөөцийн сангийн эрсдэл нь даатгалын хэлбэр тус бүр дээрх нөөцийн сангийн эрсдэлийн нийлбэртэй тэнцуу байна.
- 5.4.1 Нөөцийн сангийн эрсдэл нь тухайн даатгалын хэлбэр дээрх нөөцийн сангийн эрсдэлийн коефициентийг тухайн хэлбэрийн учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) болон мэдсэн боловч төлөгдөөгүй хохирлын нөөц сангудын (МБТХНС) нийлбэрээс нөөцийн сангийн давхар даатгагчид ногдох хэсгийг хассанаар үржүүлсэнтэй тэнцуу байна.
- 5.4.2 Нөөцийн сангийн эрсдэлийн коефициент нь тухайн хугацаанд хүлээгдэж буй УБМХНС болон МБТХНС –ын нийлбэрийн VaR (95) утга болон дундаж утгын зэрүүтэй тэнцуу байна.
- 4.3 Зээлийн эрсдэлийг банк, давхар даатгагч, авлагатай этгээд болон үнэт цаасны төрөл тус бүр дээр гаргана.
- 5.4.1 Банк болон давхар даатгагчтай холбоотой зээлийн эрсдэлийг үнэлэхдээ тухайн банк болон давхар даатгагчийн зээлжих зэрэглэлийн үнэлгээгээр тооцно.
- 5.4.2 Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Standard & Poor’s”, “Moody’s”, “Fitch” болон “IBCA” зэрэг үнэлгээний байгууллагуудаар үнэлгээ хийлгэж зээлжих зэрэглэлээ тогтоолгосон бол банк болон давхар даатгагчийн зээлийн эрсдэлийг тооцохдоо энэ үнэлгээг шууд ашиглана.
- 5.4.3 Хэрвээ тухайн хөрөнгөтэй холбоотой зээлийн эрсдэлийн үнэлгээ байхгүй бол, банк болон давхар даатгагчийн бусад үнэт цаасанд гаргасан үнэлгээг ашиглаж болно.
- 5.4.4 Хэрвээ хоёр ялгаатай зээлжих зэрэглэл тогтоогдсон бол аль мууг нь буюу илүү эрсдэлтэйг нь сонгож ашиглана.
- 5.4.5 Банк болон давхар даатгагч зээлжих зэрэглэл тогтоолгосон хэдий ч тухайн хугацаанд тогтоосон зэрэглэлээс илүү эрсдэлтэй нөхцөлд байна гэж үзвэл зээлжих зэрэглэлийг ашиглахгүй байж болно.
- 5.4.6 Хэрвээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээрх нэр дурьдсан байгууллагуудаар үнэлгээ хийлгээгүй бол зэрэглэлгүй гэсэн ангилалд оруулна.
- 5.4.7 Банктай холбоотой зээлийн эрсдэл нь тухайн банкны зээлийн эрсдэлийн коефициентийг тухайн банкинд байршуулсан хадгаламж болон хадгаламжийн сертификатийн нийлбэрээр үржүүлсэнтэй тэнцуу байна. Зээлжих зэрэглэлээс хамаарсан банкны зээлийн эрсдэлийн коефициент Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 5.4.8 Давхар даатгагчтай холбоотой зээлийн эрсдэл нь тухайн давхар даатгагчийн зээлийн эрсдэлийн коефициентийг тухайн давхар даатгагчаас авах авлага, давхар даатгалын хойшлогдсон хураамж болон нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн нийлбэрээр үржүүлсэнтэй тэнцуу байна. Зээлжих зэрэглэлээс хамаарсан давхар даатгагчийн зээлийн эрсдэлийн коефициент нь Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 5.4.9 Авлагатай этгээдтэй холбоотой зээлийн эрсдэл нь тухайн авлагын зээлийн эрсдэлийн коефициентийг авлагын хэмжээгээр үржүүлсэнтэй тэнцуу байна. Авлагын хугацаанаас хамаарсан зээлийн эрсдэлийн коефициент нь Хавсралт 1-т заасны дагуу байна.
- 5.4.10 Үнэт цаастай холбоотой зээлийн эрсдэл нь тухайн үнэт цаасны зээлийн эрсдэлийн коефициентийг үнэт цаасны цэвэр дүнгээр үржүүлсэнтэй тэнцуу

байна. Үнэт цаасны төрлөөс хамаарсан зээлийн эрсдэлийн коефициент нь Хавсралт 1-т заасны дагуу байна.

- 4.4 Зах зээлийн эрсдэлийг хадгаламжийн хүү, валютын ханш, үнэт цаас болон үндсэн хөрөнгө тус бүр дээр гаргана.
- 5.4.1 Хадгаламжийн хүүтэй холбоотой зах зээлийн эрсдэл нь хүүгийн эрсдэлийн коефициентийг хадгаламжийн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү байна. Хүүгийн эрсдэлийн коефициент нь хадгаламжийн хугацаанаас хамаарч ялгаатай байх ба хадгаламжийн хүүгийн жилийн өөрчлөлттэй тэнцүү байна.
 - 5.4.2 Валютын ханштай холбоотой зах зээлийн эрсдэл нь валютын ханшийн эрсдэлийн коефициентийг тухайн валютаар гүйлгээ хийгддэг давхар даатгалаас авах авлага, давхар даатгалын хойшлогдсон хураамж болон нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн нийлбэрээс давхар даатгагчид өгөг өглөгийг хассанаар үржүүлсэнтэй тэнцүү байна. Валютын ханшийн эрсдэлийн коефициент нь валютын төрлөөсөө хамаарч ялгаатай байх ба тухайн валютын жилийн өөрчлөлттэй тэнцүү байна.
 - 5.4.3 Үнэт цаастай холбоотой зах зээлийн эрсдэл нь үнэт цаасны эрсдэлийн коефициентийг үнэт цаасны цэвэр дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү байна. Үнэт цаасны эрсдэлийн коефициент нь үнэт цаасны төрлөөс хамаарч ялгаатай байх ба Хавсралт 2-т заасны дагуу байна.
 - 5.4.4 Үндсэн хөрөнгөтэй холбоотой зах зээлийн эрсдэл нь хөрөнгийн эрсдэлийн коефициентийг үндсэн хөрөнгийн дүнгээр үржүүлсэнтэй тэнцүү байна. Хөрөнгийн эрсдэлийн коефициент нь үндсэн хөрөнгийн төрлөөс хамаарч ялгаатай байх ба Хавсралт 2-т заасны дагуу байна.
- 4.5 Стратегийн эрсдэлийг Хавсралт 3-т заасан эрсдэлийн үнэлгээний дагуу үнэлнэ.
- 4.6 Үйл ажиллагааны эрсдэлийг Хавсралт 4-т заасан эрсдэлийн үнэлгээний дагуу үнэлнэ.
- 4.7 Комплайнсийн эрсдэлийг Хавсралт 5-т заасан эрсдэлийн үнэлгээний дагуу үнэлнэ.
- 4.8 Эрсдэл даах чадварыг эрсдэл тус бүр дээр тодорхойлох ба эрсдэлийн нөхцөл байдалтай уялдуулан жилд нэг удаа өөрчлөлт оруулж болно.
- 4.9 Эрсдэлийн аппетитийг эрсдэл тус бүрийн эрсдэл даах чадварыг харгалзан тогтоох ба эрсдэлийн нөхцөл байдалтай уялдуулан жилд нэг удаа өөрчлөлт оруулж болно.

5. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА БА ХЯНАЛТ

- 5.1 Эрсдэлийн удирдлагын алба нь эрсдэл бүр дээр эрсдэлийн үнэлгээг улирал тутамд хийх ба эрсдэл даах чадвараас давсан эрсдлүүд дээр эрсдэлийн удирдлагын стратеги боловсруулан удирдлагын хороонд танилцуулна.
- 5.2 Эрсдэл даах чадвараас давсан эрсдлүүд дээр хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын стратегийг удирдлагын хороо хэлэлцэн батлана.
- 5.3 Удирдлагын хорооноос гаргасан эрсдэлийн удирдлагын стратегийг тухайн эрсдлийг хариуцсан газар, хэлтэс хэрэгжүүлэх ба хэрэгжилтэнд эрсдэлийн удирдлагын алба хяналт тавина.
- 5.4 Эрсдэлийн шинж чанар, ялгаатай байдлаас шалтгаалан үндсэн таван бүлэг эрсдэл тус бүр дээр дараах эрсдэлийн удирдлагын стратегиудыг хэрэгжүүлж болох ба нөхцөл байдлаас шалтгаалан дор дурдснаас өөр стратегийг хэрэгжүүлэх боломжтой..
- 5.4.1 Даатгалын эрсдэлийг бууруулахын тулд богино хугацааны давтамжтай өгөгдлийн шинжилгээ хийх, үүрч буй хариуцлагын хэмжээг тогтмол хянах зэрэг арга хэмжээнүүдийг авна.
 - 5.4.2 Санхүүгийн эрсдэлийг бууруулахын тулд зээл болон зах зээлийн эрсдэлд холбогдох хөрөнгийг тараан байршуулах буюу эрсдэлийн төрөлжүүлэлт хийх

болон дериватив зэрэг санхүүгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнүүдийг авна.

- 5.4.3 Стратегийн эрсдэлийг бууруулахын тулд засаглал, андеррайтинг, давхар даатгал болон хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлох, сайжруулах, биелэлтэнд хяналт тавих арга хэмжээг авна.
- 5.4.4 Үйл ажиллагааны болон комплайнсын эрсдэлийг бууруулахын тулд дотоод үйл ажиллагааны журмыг сайжруулах, хэрэгжилтэнд хяналт тавих арга хэмжээг авна.

6. ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ХАРЬЦААГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

- 6.1 Компанийн төлбөрийн чадварын байдлыг эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээний харьцаагаар тодорхойлно.
- 6.2 Эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээний харьцааг зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг зайлшгүй байх хөрөнгийн дүнд хуваах замаар буюу дараах томьёогоор тооцно. Зайлшгүй байх хөрөнгийн дүн нь эрсдэлд суурилсан хөрөнгө болон дүрмийн сангийн доод хэмжээний аль ихтэй нь тэнцүү байна.

$$XXX = 3X / \max(\text{ЭСХ}, \text{ДСДХ}) * 100\%$$

XXX – Хөрөнгийн хүрэлцээний харьцаа;

3X – Зөвшөөрөгдөх хөрөнгө;

ЭСХ – Эрсдэлд суурилсан хөрөнгө;

ДСДХ – Дүрмийн сангийн доод хэмжээ

- 6.3 Зөвшөөрөгдөх хөрөнгийн дүнг даатгачийн нийт хөрөнгөөс зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн дүнг хасах замаар буюу дараах томьёогоор тооцно.

$$3X = NX - [DX + (OT - THC)]$$

3X – Зөвшөөрөгдөх хөрөнгө;

NX – Нийт хөрөнгө;

DX – Даатгалын хөрөнгө;

OT – Өр төлбөр;

THC – Тусгай нөөц сан

- 6.4 Эрсдэлд суурилсан хөрөнгийн хэмжээг дараах томьёогоор тооцно.

$$\text{ЭСХ} = \sqrt{\text{Эрсдэл}_{\text{даатгал}}^2 + \text{Эрсдэл}_{\text{зээл}}^2 + \text{Эрсдэл}_{\text{зз}}^2 + \text{Эрсдэл}_{\text{бусад}}}$$

ЭСХ – Эрсдэлд суурилсан хөрөнгө;

Эрсдэл_{даатгал} – Даатгалын эрсдэл;

Эрсдэл_{зээл} – Зээлийн эрсдэл;

Эрсдэл_{зз} – Зах зээлийн эрсдэл;

Эрсдэл_{бусад} – Үйл ажиллагаа, стратеги болон комплайнсын эрсдлүүдийн нийлбэр;

- 6.5 Даатгалын эрсдэлийг хураамж болон нөөц сангийн эрсдэлүүдийн квадрат дундаж буюу дараах томьёогоор тооцно.

$$\text{Эрсдэл}_{\text{даатгал}} = \sqrt{\text{Эрсдэл}_{\text{хураамж}}^2 + \text{Эрсдэл}_{\text{HC}}^2}$$

**"Монгол Даатгал" ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 06 дугаар сарын 24-ний
өдрийн № 21/20 тоот тогтоолын Хавсралт №01**

Эрсдэл_{даатгал} – Даатгалын эрсдэл;

Эрсдэл_{хураамж} – Хураамжийн эрсдэл;

Эрсдэл_{nc} – Нөөцийн сангийн эрсдэл

- 6.6 Зээлийн эрсдэлийг банк, давхар даатгагч, авлага болон хөрөнгийн зах зээлийн эрсдэлүүдийн квадрат дундаж буюу дараах томьёогоор тооцно.

$$\text{Эрсдэл}_{\text{зээл}} = \sqrt{\text{Эрсдэл}_{\text{банк}}^2 + \text{Эрсдэл}_{\text{дд}}^2 + \text{Эрсдэл}_{\text{ав}}^2 + \text{Эрсдэл}_{\text{хөр}}^2}$$

Эрсдэл_{зээл} – Зээлийн эрсдэл;

Эрсдэл_{банк} – Банктай холбоотой зээлийн эрсдэл;

Эрсдэл_{дд} – Давхар даатгагчтай холбоотой зээлийн эрсдэл;

Эрсдэл_{ав} – Авлагатай холбоотой зээлийн эрсдэл;

Эрсдэл_{хөр} – Хөрөнгийн зах зээлтэй холбоотой зээлийн эрсдэл;

- 6.7 Зах зээлийн эрсдэлийг хадгаламжийн хүү, валютын ханш, хөрөнгийн зах зээл болон Үндсэн хөрөнгийн эрсдэлүүдийн квадрат дундаж буюу дараах томьёогоор тооцно.

$$\text{Эрсдэл}_{\text{зз}} = \sqrt{\text{Эрсдэл}_{\text{хүү}}^2 + \text{Эрсдэл}_{\text{ханш}}^2 + \text{Эрсдэл}_{\text{хөрzz}}^2 + \text{Эрсдэл}_{\text{хөрөнгө}}^2}$$

Эрсдэл_{зз} – Зах зээлийн эрсдэл;

Эрсдэл_{хүү} – Хадгаламжийн хүүтэй холбоотой зах зээлийн эрсдэл;

Эрсдэл_{ханш} – Валютын ханштай холбоотой зах зээлийн эрсдэл;

Эрсдэл_{хөрzz} – Хөрөнгийн зах зээлтэй холбоотой зах зээлийн эрсдэл;

Эрсдэл_{хөрөнгө} – Үндсэн хөрөнгөтэй холбоотой зах зээлийн эрсдэл;

- 6.8 Тоогоор хэмжих боломжгүй буюу чанараар хэмждэг үйл ажиллагаа, стратеги, комплайнсийн эрсдэлүүдийн нийлбэрийг дараах томьёогоор тооцно.

$$\text{Эрсдэл}_{\text{бусад}} = 3\% * (\text{НХ} - \text{ДХ})$$

Эрсдэл_{бусад} – Үйл ажиллагаа, стратеги, комплайнсийн эрсдэлүүдийн нийлбэр;

НХ – Нийт хөрөнгө;

ДХ – Даатгалын хөрөнгө

7. ЭРСДЭЛИЙН ТАЙЛАГНАЛ

- 7.1 Эрсдэлийн тайлагналын гол зорилго нь эрсдэлийн мэдээллийн сан үүсгэх, эрсдэлийн удирдлагын хариуцлагыг нэмэгдүүлэх болон эрсдэлийн удирдлагын арга хэмжээнүүдийг урьдчилан авч хэрэгжүүлэх боломжийг олгох юм.
- 7.2 Эрсдэлийн удирдлагын алба нь улирал бүр эрсдэлийн тайлан гаргаж удирдлагын хороонд танилцуулна.
- 7.3 Эрсдэлийн удирдлагын алба нь жилд нэг удаа "Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан" болон "Эрсдэлд сууринсан хөрөнгийн хүрэлцээний харьцаа"-г гаргаж СЗХ болон олон нийтэд нээлттэй байдлаар тайлагнана.

8. ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. Зээлийн эрсдэлийн коефициент

Хүснэгт 1. Банктай болон давхар даатгагчтай холбоотой зээлийн эрсдэлийн коефициент.

Зээлжих зэрэглэл	Эрсдэлийн коефициент
Баталгаажсан	0.0%
АА болон дээш	1.6%
А	4.0%
BBB	8.0%
BB	16.0%
В буюу түүнээс доош	24.0%
Үнэлгээгүй, баталгаажсан	30.0%
Үнэлгээгүй, баталгаажаагүй	100.0%

Хүснэгт 2. Авлагатай холбоотой зээлийн эрсдэлийн коефициент.

Авлагын төрөл	Эрсдэлийн коефициент
Хэвийн	0%
Хугацаа хэтэрсэн	25%
Хэвийн бус	50%
Эргэлзээтэй	100%
Muy	100%

Хүснэгт 3. Үнэт цаастай холбоотой зээлийн эрсдэлийн коефициент.

Үнэт цаас	Эрсдэлийн коефициент
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	0.0%
Төв банкны үнэт цаас	0.0%
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	10.0%
Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	10.0%
Компанийн өрийн хэрэгсэл	20.0%
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 аngилал	20.0%
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 аngилал	30.0%
Хөрөнгө оруулалтын нээлттэй сан	30.0%
Хөрөнгө оруулалтын хаалттай сан	30.0%
Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл	5.0%
Гадаадын Төв банкны үнэт цаас	5.0%
Гадаадын компанийн өрийн хэрэгсэл	20.0%
Гадаадын компанийн хувьцаа	20.0%

ХАВСРАЛТ 2. Зах зээлийн эрсдэлийн коэффициент

Хүснэгт 4. Үнэт цаастай холбоотой зах зээлийн эрсдэлийн коэффициент

Үнэт цаас	Эрсдэлийн коэффициент
ХХК	20%
ХК - Борлуулахад бэлэн үнэт цаас	10%
ХК - Хугацааны эцэс хүртэл эзэмших үнэт цаас	20%
Хараат ба хамтын хяналттай, охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт	30%
Үнэт металл, Дериватив	30%

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгөтэй холбоотой зах зээлийн эрсдэлийн коэффициент

Үндсэн хөрөнгө	Эрсдэлийн коэффициент
Газрын сайжруулалт	5%
Барилга байгууламж	10%
Машин тоног төхөөрөмж	10%
Тээврийн хэрэгсэл	10%
Тавилга эд хогшил	10%
Компьютер дагалдах хэрэгсэл	10%
Санхүүгийн түрээсийн хөрөнгө	5%
Мал сүрэг	15%

ХАВСРАЛТ 3. Стратегийн эрсдэлийн үнэлгээ

Хүснэгт 6. Засаглалын эрсдэлийн үнэлгээ

Холбоотой этгээд	Эрсдэлийн үнэлгээний асуулга	Тийм = 0; Үгүй = 1
Төлөөлөн удирдах зөвлөл	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, мөрддөг эсэх?	
	Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх чиглэлээр дотоод журмуудыг баталж, мөрддөг эсэх?	
	Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тодорхойлсон дотоод журам, гэрээг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьсан эсэх?	
	Компанийн ёс зүйн дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ёс зүйн талаар тусгасан эсэх?	
Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг баталж, тайлагнадаг эсэх?	
	Төлөөлөн удирдах зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлсэн эсэх?	
	Хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдсэн эсэх?	
Гүйцэтгэх удирдлага	Нэр дэвшүүлэх хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт гаргасан эсэх?	
	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн эсэх?	
	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг Нэр дэвшүүлэх хороо дүгнэсэн эсэх?	
	Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилласан эсэх?	
	Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлд шаардлагатай мэдээ, мэдээлэл болон тайлант хугацааны ажлын тайланг тухай бүр танилцуулсан эсэх?	
	Бүх захирлууд нь бие даасан байж чаддаг уу?	
Нийт		
Үр дүн		
Эрсдэлийн түвшин бага		2 ба түүнээс доош
Эрсдэлийн түвшин дунд		3 – 4
Эрсдэлийн түвшин өндөр		5 ба түүнээс дээш

Хүснэгт 7. Бодлогын эрсдэлийн үнэлгээ

Холбогдох бодлого, төлөвлөгөө	Эрсдэлийн үнэлгээний асуулга	Тийм = 0; Үгүй = 1
Давхар даатгалын бодлого	Давхар даатгалын үйл ажиллагааны журамтай эсэх?	
	Давхар даатгалын хэрэгцээ шаардлагыг зөв тооцоолсон эсэх? Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харах	
	Давхар даатгалын төлөвлөгөөг СЗХ-оор хянуулсаны дагуу явуулсан уу?	
Андеррайтингийн бодлого	Андеррайтингийн бодлоготой эсэх?	
	Андеррайтингийн бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьдаг эсэх?	
	Тодорхой хугацааны давтамжтай андеррайтингийн бодлогын үр дүнг үнэлэн, сайжруулалт хийдэг эсэх?	
Хөрөнгө оруулалтын бодлого	Хөрөнгө оруулалтын бодлоготой эсэх?	
	Хөрөнгө оруулалтын бодлого нь СЗХ-ноос тавьсан шаардлагыг хангадаг эсэх?	
	Хөрөнгө оруулалтын бодлого оновчтой эсэх? Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харах	
Нийт		
Үр дүн		
Эрсдэлийн түвшин бага		2 ба түүнээс доош
Эрсдэлийн түвшин дунд		3-4
Эрсдэлийн түвшин өндөр		5 ба түүнээс дээш

ХАВСРАЛТ 4. Үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээ

Эрсдэлийн үнэлгээний асуулга	Тийм = 0; Үгүй = 1
Үйл ажиллагааны эрсдэлийг удирдахтай холбоотой зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?	
Компанийн удирдлага, ажилтнууд хоорондын сонирхолын зэрчлийг зохицуулах талаар холбогдох журамд тусгасан уу?	
Хөрөнгийн хөрвөх чадварын удирдлагын талаар холбогдох журамд тусгасан уу?	
Гамшиг, цар тахал, томоохон аюул ослыг удирдах төлөвлөгөө байдаг уу?	
Дотоод хяналтын үйл ажиллагааны журамтай юу?	
Дотоод хяналтыг ямар давтамжтайгаар хэрэгжүүлдэг вэ?	
Компанийн актуарч нь СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй юу?	
Даатгалын нөөц санг хөндлөнгийн мэргэшсэн актуарчаар хянуулдаг уу?	
СЗХ-нд хүргэгдсэн санал гомдол нь үндэслэлтэй байдаг уу?	
Нэхэн төлбөр олгох талаар холбогдох журамд тусгагдсан уу?	
Даатгал болон санхүүгийн мэдээллийн нэгдсэн системтэй юу?	
Салбарын мэдээлэл нь төв системтэй холбогдсон уу?	
Ажилтнуудын сургалтын хөтөлбөр байдаг уу?	
Даатгалын төлөөлөгч нарын сургалтыг ямар давтамжтай явуулдаг вэ?	
Ажлын байрны стандартыг тогтоосон журамтай юу?	
Ажилтан, албан тушаалтнуудын ажлын байранд баримтлах стандартыг тогтоосон журам ба ёс зүйн дүрэмтэй юу?	
Нийт	
Үр дүн	
Эрсдэлийн түвшин бага	3 ба түүнээс доош
Эрсдэлийн түвшин дунд	4 – 5
Эрсдэлийн түвшин өндөр	6 ба түүнээс дээш


ХАВСРАЛТ 5. Эрсдэлийн тайланд орох эрсдэлийн хэмжигдэхүүнүүд, аппетит

Эрсдэлийн бүлэг	Эрсдэлийн хэмжигдэхүүн	Эрсдэлийн аппетит	2019'I V	2020'I V	2021'I
Даагалын эрсдэл	Цэвэр хосолмол харьцааны өөрчлөлт	[-10%; 5%]			
	Нийт хураамжийн өөрчлөлт	[-10%; 20%]			
	Цэвэр хураамжийн өөрчлөлт	[-10%; 20%]			
	Гарах МҮ-ын ЦХО-д харьцуулалт	<= 105%			
	Хохирлын харьцааны өөрчлөлт	<= 5%			
	Хураамжийн хувийн бууралт	<= 3/20			
	Нөөц сангийн дутагдлын ЭӨ-д харьцуулалт	<= 20%			
Зээлийн эрсдэл	ДД-гүй Трити-с давсан гэрээний тоо	<= 10 гэрээ			
	МБ-ны шалгуур үзүүлэлт хангахгүй болсон банкинд байршуулсан хөрөнгийн хэмжээ	<= 500 сая төгрөг			
	Авлагын ЭӨ-д харьцуулалт	<= 25%			
	Retention ratio	>= 60%			
Зах зээлийн эрсдэл	Хөрөнгө оруулалтын өгөөжийн 33-н дунджаас	[-1%; 2%]			
	Хувьцаа болон компанийн бондын нийт хөрөнгөд харьцуулалт	<= 10%			
	Хөрөнгийн өгөөжийн зах зээлийн дунджаас	>= -5%			
	Эздийн өмчийн өгөөжийн зах зээлийн дунджаас	>= -5%			
Гол харьцаанууд	Төлбөрийн чадварын харьцаа	>= 115%			
	Хос харьцаа зах зээлийн дундажтай харьцуулахад	[-10%; 5%]			
	Хохирлын харьцаа	[-10%; 5%]			
	Зардлын харьцаа	[-10%; 5%]			

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО

1. Эрсдэлийн удирдлагын бодлогын зорилго нь даатгагчийн санхүүгийн тогтвортой байдлыг хангаж ажилласнаар даатгуулагчдын болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах явдал юм.
2. Энэхүү баримт бичгийг компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бурдуулэх, хэрэгжүүлэх, хянахад баримталж ажиллана.
3. ТУЗ нь дотооддоо мөрдөх эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгийг байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
4. ТУЗ нь байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангах нэгдсэн үйл ажиллагааг хариуцна.
5. ТУЗ нь эрсдэлийн удирдлагын бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд бодлогын баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр Хавсралт №1-ийн дагуу шинэчлэн батална. ТУЗ-ын дэргэдэх аудитын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.
6. Бодлогын баримт бичгээр байгууллагын зорилго, зорилтод нөлөөлөх эрсдэл, тэдгээрийн тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, эрсдэлийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.
7. Эрсдэлийн удирдлагыг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ:
 - 7.1. Эрсдэлийг тодорхойлох: тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:
 - Эрсдэлийн шинж чанар /nature of risk/
 - Эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/
 - Эрсдэлийн шалтгаан /cause of the risk/
 - Эрсдэлийн нөлөө /effect of the risk/
 - 7.2. Эрсдэлийг үнэлэх: эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилж, хэмжих ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.
 - 7.3. Эрсдэлийг удирдах: эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.
8. Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, байгууллагын эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдлах үйл ажиллагааг явуулна.
9. Гүйцэтгэх удирдлагын дэргэд байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан байх бөгөөд бусад гүйцэтгэх шатны удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.
10. Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгж эсхүл ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө тухайн байгууллагад нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

“Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 06 дугаар сарын 24-ний
өдрийн № 21/20 тоот тогтоолын Хавсралт №02



Хавсралт 1. Эрсдэлийн аппетит

№	Эрсдэлийн хэмжигдэхүүн	Эрсдэлийн аппетит
1	Нийт хураамжийн өөрчлөлт	[-10%; 30%]
2	Хосолмол харьцаа	<= 105%
3	Хохирлын харьцааны зах зээлийн дундажтай харьцуулалт	<= 5%
4	Зардлын харьцааны зах зээлийн дундажтай харьцуулалт	<= 5%
5	Төлбөрийн чадварын харьцаа	>= 115%
6	Авлагын эздийн өмчид харьцуулалт	<= 25%
7	Хөрөнгө оруулалтын өгөөжийн зах зээлийн дундажтай харьцуулалт	[-1%; 2%]
8	Хөрөнгийн өгөөжийн зах зээлийн дундажтай харьцуулалт	>= -5%
9	Эздийн өмчийн өгөөжийн зах зээлийн дундажтай харьцуулалт	>= -5%

“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХӨТӨЛБӨР

1. Энэхүү баримт бичиг нь “Монгол Даатгал” ХК-ийн дунд хугацааны буюу 2-3 жилийн хугацаанд эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.
2. 2021 оны эхний хагас жилд багтан эрсдэлийн удирдлагын баримт бичгүүд болох эрсдэлийн удирдлагын бодлого, журам, хөтөлбөр болон төлөвлөгөөг ТУЗ-аар батлуулж, эрсдэлийн тайлагналын системийг бий болгоно.
3. Даатгалын бус авлагын дүнг 2022 оны эцэс гэхэд 1 тэрбум төгрөгөөс бага дунд хүргэнэ.
4. Эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтын мөнгөн хөрөнгийг 2021 он гэхэд бүрэн буцаан татан төвлөрүүлнэ.
5. Нөхөн төлбөрийн нөөц сангудыг журмын дагуу тасралтгүй нэмэгдүүлсээр 2022 оны эцэст нөөцийг дутуу байгуулсан явдлыг бүрэн арилгах.
6. Компанийн ашигт ажиллагааг илтгэх хөрөнгийн өгөөж, эзэмшигчдийн өмчийн өгөөж нь зах зээлийн дунджаас 5 хувиас доошгүй хувь байна.
7. Санхүүгийн тайлангийн аливаа дүн нь үндсэн програм дээрх дүнтэй зөрүүгүй болох, даатгалын борлуулалтын тайлан, зүйлийн тайлан, нөхөн төлбөрийн тайланг алдаагүй програмаас гардаг болгох.



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Энэхүү баримт бичиг нь “Монгол Даатгал” ХК-ийн богино хугацааны буюу 1 жилийн хугацаанд эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө юм.
2. 2021 оны эхний хагас жилд багтан эрсдэлийн удирдлагын баримт бичгүүд болох эрсдэлийн удирдлагын бодлого, журам, хөтөлбөр болон төлөвлөгөөг ТУЗ-аар батлуулж, эрсдэлийн тайлагналын системийг бий болгоно.
3. Даатгалын бус авлагын дүнг 2021 оны эцэс гэхэд 2.3 тэрбум төгрөгөөр бууруулах, хэвийн бус авлагуудын эргэн төлөлтийн графикийг шинэчлэн, мөрдөж ажиллана.
4. Чингисхаан банкнаас 1 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэх.
5. 2021 оныг дуустал улирал бүр Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн шүүх дээр байгаа нэхэмжлэлийг тасралтгүй өсгөн нэмэгдүүлж байгуулна.
6. Санхүүгийн тайлангийн аливаа дүн нь үндсэн програм дээрх дүнтэй зөрүүгүй болох, даатгалын борлуулалтын тайлан, зүйлийн тайлан, нөхөн төлбөрийн тайланг алдаагүй програмаас гардаг болгох.



“МОНГОЛ ДААТГАЛ” ХК-ИЙН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

Тийм	Хангалттай	
Үгүй	Зарим тохиолдолд хангалтгүй	
	Хангалтгүй	

1. Хураамжийн эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Андеррайтингийн эрсдэлийг хянаж, зохицуулах талаарх зохицуулалт холбогдох журамд тусгагдсан уу?	Тийм	0
2	Андеррайтингийн үйл ажиллагаа нь холбогдох зохицуулалтын дагуу хийгдэж байна уу?	Үгүй	1
3	Шинэ бүтээгдэхүүн гаргах бүртээ зах зээлийн судалгаа, бүтээгдэхүүний загвар, туршилт төлөвлөлтийг хангалттай түвшинд хийдэг үү?	Тийм	0
4	Даатгалын хураамжийг тогтсон аргачлалын дагуу тооцоолдог уу?	Тийм	0
5	Давхар даатгалын үйл ажиллагааг СЗХ -оор хянуулсан төлөвлөгөөний дагуу явуулсан уу?	Тийм	0
6	Зах зээл дээр борлуулагдаж байгаа бүх даатгалын бүтээгдэхүүн нь СЗХ-нд бүртгүүлсэн үү?	Тийм	0
7	Нийт хохирлын харьцаа нь 60 % -аас бага уу?	Тийм	0
8	Нийт зардлын харьцаа нь 50% -аас бага уу?	Үгүй	2
9	Нийт хосолсон харьцаа нь 105% -аас бага уу?	Үгүй	2
Хураамжийн эрсдэлийн нийт үнэлгээ			5
Хураамжийн эрсдэлийн түвшин			Дунд

2. Нөөцийн сангийн эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг журмын дагуу тооцдог уу?	Хангалттай	0
2	Учирч болзошгүй хохирлын нөөц санг журмын дагуу тооцоолсон уу?	Хангалттай	0
3	Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг журмын дагуу тооцоолсон уу?	Хангалттай	0
4	Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг журмын дагуу тооцоолсон уу?	Хангалттай	0
5	Компани даатгалын нөөц санг хөндлөнгийн мэргэшсэн актуарчаар хянуулдаг уу?	Тийм	0
Нөөцийн сангийн эрсдэлийн нийт үнэлгээ			0
Нөөцийн сангийн эрсдэлийн түвшин			Бага

Тийм	Бага	Хангалттай
Үгүй	Дунд	Зарим тохиолдолд хангалтгүй
	Их	Хангалтгүй

3. Зээлийн эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Зээлийн эрсдэлийг удирдах талаарх зохицуулалт компанийн холбогдох журамд тусгагдсан уу?	Тийм	0
2	Зээлийн эрсдэлийн удирдлагыг үйл ажиллагаандaa мөрдөж ажилладаг уу?	Үгүй	1
3	Холбогдох этгээдтэй холбоотой авлага, тооцоо байна уу?	Дунд	1
4	Хугацаа хэтэрсэн авлага байна уу?	Дунд	1
5	Хугацаа хэтэрсэн авлагад эрсдэлийн сан байгуулдаг уу?	Тийм	0
6	Хугацаа хэтэрсэн авлага, тооцоог удирдах болон цуглуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг үү?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
7	Хураамжийн авлага, эзэмшигчийн өмчийн харьцаа 20% - аас бага уу?	Тийм	0


 МС
 20323

“Монгол Даатгал” ХК-ийн ТУЗ-ийн 2021 оны 06 дугаар сарын 24-ний
өдрийн № 21/20 тоот тогтоолын Хавсралт №05

8	Нийт авлага, нийт хөрөнгийн харьцаа 20% - аас бага уу?	Үгүй	1
9	Олон улсын үнэлгээний байгууллагуудаас зээлжих зэрэглэл аваагүй банкинд хадгаламж байршуулдаг эсэх?	Тийм	1
10	Олон улсын үнэлгээний байгууллагуудаас зээлжих зэрэглэл аваагүй давхар даатгалд даатгуулдаг эсэх?	Тийм	1
Зээлийн эрсдэлийн нийт үнэлгээ			7
Зээлийн эрсдэлийн түвшин			Их

4. Зах зээлийн эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хууль тогтоомжинд заасны дагуу хийлгэсэн үү?	Хангалттай	0
2	Хөрөнгийн дансны үнэ нь зах зээлийн үнээс хэтэрсэн тохиолдолд хөрөнгийн үнэ цэнийг бууруулах талаар холбогдох журамд тусгасан уу?	Тийм	0
3	Гадаад валютын эрсдэлийг хянаж үнэлэх талаар холбогдох журамд тусгасан уу?	Хангалтгүй	2
4	Хадгаламжийн хүүгийн эрсдэлийг хянаж үнэлэх талаар холбогдох журамд тусгасан уу?	Хангалтгүй	2
5	Нөөц сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг СЗХ -р хянуулсан уу?	Хангалттай	0
6	Нөөц сангийн хөрөнгө оруулалтыг СЗХ -оор хянуулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хийсэн үү?	Хангалттай	0
Зээлийн эрсдэлийн нийт үнэлгээ			4
Зах зээлийн эрсдэлийн түвшин			Дунд

Хангалттай	Тийм
Зарим тохиолдолд хангалтгүй	Үгүй
Хангалтгүй	

5. Засаглалын эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, мөрддөг эсэх?	Зарим тохиолдолд хангалтгүй	1

2	Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх чиглэлээр дотоод журмуудыг баталж, мөрддөг эсэх?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
3	Гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээг тодорхойлсон дотоод журам, гэрээг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьсан эсэх?	Хангалтгүй	2
4	Компанийн ёс зүйн дүрэмд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ёс зүйн талаар тусгасан эсэх?	Тийм	0
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны журмыг баталж, тайлагнадаг эсэх?	Хангалттай	0
6	Төлөөлөн удирдах зөвлөл нь жилийн ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлсэн эсэх?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
7	Хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүдээс бүрдсэн эсэх?	Тийм	0
8	Нэр дэвшүүлэх хороо нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт гаргасан эсэх?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
9	Аудитын хорооны дарга нь хараат бус гишүүн эсэх?	Тийм	0
10	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг Нэр дэвшүүлэх хороо дүгнэсэн эсэх?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
11	Бүх захирлууд нь бие даасан байж чаддаг уу?	Зарим тохиолдолд хангалтгүй	1
12	Ахлах, удирдлагуудын эрх үүрэг, хариуцлага, тайлагнал нь ойлгомжтой тодорхойлогдсон эсэх?	Хангалтгүй	2
Засаглалын эрсдэлийн нийт үнэлгээ			10
Засаглалын эрсдэлийн түвшин			Их

6. Андеррайтингийн бодлогын эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Андеррайтингийн бодлоготой эсэх?	Үгүй	2
2	Андеррайтингийн бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьдаг эсэх?	Үгүй	1
3	Тодорхой хугацааны давтамжтай андеррайтингийн бодлогын үр дүнг үнэлэн, сайжруулалт хийдэг эсэх?	Үгүй	1
4	Жилийн нийт хураамжийн өөрчлөлт - 33% аас 33%-ийн хооронд байгаа эсэх?	Тийм	0

5	Жилийн цэвэр хураамжийн өөрчлөлт - 33% аас 33%-ийн хооронд байгаа эсэх?	Тийм	0
6	Цэвэр хураамж болон эзэмшигчийн өмчийн харьцаа 3-аас бага эсэх?	Тийм	0
7	Нийт хураамж болон эзэмшигчийн өмчийн харьцаа 7-оос бага эсэх?	Тийм	0
	Андеррайтингийн бодлогын эрсдэлийн нийт үнэлгээ	4	
	Андеррайтингийн бодлогын эрсдэлийн түвшин	Дунд	

7. Давхар даатгалын бодлогын эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Давхар даатгалын үйл ажиллагааны журамтай эсэх?	Тийм	0
2	Давхар даатгалын хэрэгцээ шаардлагыг зөв тооцоолсон эсэх? Сүүлийн 3 жилийн үзүүлэлтээс харах	Зарим тохиолдолд хангалтгүй	1
3	Давхар даатгалын үйл ажиллагааг СЗХ-р хянуулсан төлөвлөгөөний дагуу явуулдаг уу?	Тийм	0
4	Цэвэр хураамж болон нийт хураамжийн харьцаа 40% - 80% ийн хооронд байгаа эсэх?	Тийм	0
	Давхар даатгалын бодлогын эрсдэлийн нийт үнэлгээ	1	
	Давхар даатгалын бодлогын эрсдэлийн түвшин	Бага	

8. Хөрөнгө оруулалтын бодлогын эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Хөрөнгө оруулалтын бодлоготой эсэх?	Үгүй	2
2	Хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилтэнд хяналт тавьдаг эсэх?	Үгүй	1
3	Тодорхой хугацааны давтамжтай хөрөнгө оруулалтын бодлогын үр дүнг үнэлэн, сайжруулалт хийдэг эсэх?	Үгүй	1
4	Нөөц сангийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг СЗХ-оор хянуулсан уу?	Тийм	0
5	Нөөц сангийн хөрөнгө оруулалтыг СЗХ-оор хянуулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу хийсэн үү?	Тийм	0
6	Хөрөнгө оруулалтын өгөөж ЗГ-ын өрийн бичгийн 6 сарын дундаж хүүгээс багагүй байгаа юу?	Үгүй	2
	Хөрөнгө оруулалтын бодлогын эрсдэлийн нийт үнэлгээ	6	
	Хөрөнгө оруулалтын бодлогын эрсдэлийн түвшин	Их	

Тийм	Улирал бүр	Бүгд	Жил бүр	Хангалттай
Үгүй	Хагас жил бүр	Зарим нь	1 - 3 жил тутам	Зарим тохиолдолд хангалтгүй
	Жилээс дээш	Огт үгүй	3 жилээс дээш	Хангалтгүй

9. Үйл ажиллагааны эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Үйл ажиллагааны эрсдэлийг удирдахтай холбоотой зохицуулалтыг холбогдох журамд тусгасан уу?	Тийм	0
2	Компанийн удирдлага, ажилтнууд хоорондын сонирхлын зөрчлийг зохицуулах талаар холбогдох журамд тусгасан уу?	Үгүй	1
3	Хөрөнгийн хөрвөх чадварын удирдлагын талаар холбогдох журамд тусгасан уу?	Үгүй	1
4	Гамшиг, томоохон хэмжээний аюул ослыг удирдах төлөвлөгөө байдаг уу?	Үгүй	1
5	Дотоод хяналтын үйл ажиллагааны журамтай юу?	Тийм	0
6	Дотоод хяналтыг ямар давтамжтай хэрэгжүүлдэг вэ?	Хагас жил бүр	1
7	Компанийн актуарч нь актуарын эрхийг СЗХ -оос авсан уу?	Тийм	0
8	Даатгалын нөхөн төлбөр олгох талаар холбогдох журамд тусгасан уу?	Тийм	0
9	СЗХ-д ирсэн өргөдөл, гомдол нь үндэслэлтэй байдаг уу?	Зарим нь	1
10	Хууран мэхлэх үйл ажиллагааг тодорхойлох, олж илрүүлэх талаар бодлого, зохицуулалт байдаг уу?	Тийм	0
11	Даатгал болон санхүүгийн мэдээллийн нэгдсэн системтэй юу?	Тийм	0
12	Салбарын мэдээлэл нь төв системтэй холбогдсон уу?	Тийм	0
13	Ажилтнуудын сургалтын хөтөлбөр байдаг уу?	Тийм	0
14	Даатгалын төлөөлөгч нарын сургалтыг ямар давтамжтай явуулдаг вэ?	1 - 3 жил тутам	1

Үйл ажиллаагааны эрсдэлийн нийт үнэлгээ	6
Үйл ажиллаагааны эрсдэлийн түвшин	Дунд

10. Хууль зохицуулалтын хүрээний эрсдэл

№	Асуулт	Хариулт	Эрсдэлийн үнэлгээ
1	Даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хөрөнгөө шилжүүлэхэд тавигдах шаардлагыг хангаж ажилласан уу?	Хангалттай	0
2	Даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан урьдчилгаа болон зээлтэй холбоотой хязгаарлалтыг хэрэгжүүлж ажилласан уу?	Хангалттай	0
3	Даатгалын тухай хуульд заасны дагуу нягтлан бодох бүртгэлээ зохих ёсоор хөтөлсөн үү?	Хангалттай	0
4	Даатгалын тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий албан тушаалтныг томилохдоо СЗХ-оос зөвшөөрөл авч ажилласан уу?	Хангалттай	0
5	Даатгалын тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу даатгалын үйл ажиллагааг зохистой явуулсан уу?	Хангалттай	0
6	Сүүлийн 2 жилд даатгалын тухай хуулийн дагуу компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж байсан уу?	Үгүй	0
7	Даатгалын тухай хуулийн бусад зүйл, заалтыг хэрэгжүүлж ажилласан уу?	Хангалттай	0
8	Жолоочийн даатгалын тухай хуулийг бүрэн мөрдөж ажилласан уу?	Хангалттай	0
9	Иргэний хуулийн даатгалтай холбоотой харилцааг зохицуулсан 43 дугаар бүлгийг бүрэн мөрдөж ажилласан уу?	Хангалттай	0
10	Даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг мөрдөж ажилласан уу?	Хангалттай	0
11	Компанийн санхүүгийн тайлан, нэмэлт тайлангуудыг цаг хугацаанд нь ирүүлсэн үү?	4 улирал хангасан	0
Хууль зохицуулалтын хүрээний эрсдэлийн үнэлгээ			0
Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэлийн түвшин			Бага